



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 40

Мөрөн

Үндсэн хөрөнгө худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн эзэмшилд илүүдэлтэй, засварлаж ашиглахад эдийн засгийн хувьд ашиггүй болсон барилга байгууламж бусад хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэж хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийн дуудлага худалдааг хууль журмын хүрээнд зохион байгуулж орлогыг журмын дагуу аймгийн Хөрөнгө борлуулсны орлогын данс болон холбогдох дансанд төвлөрүүлэх, зарцуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

3. Дор дурдсан арга хэмжээг авч, биелэлтийг гарган Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Лхагважав)-д даалгасугай:

а. Худалдан борлуулсан газар эзэмших эрхийг хууль журмын дагуу худалдан авсан этгээдэд шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах

б. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

в. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Билэгт-Отгон)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

119150124

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ийн 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралт

Хөвсгөл Ус суваг ХХК-ийн дуудлага худалдаанд оруулах хөрөнгө

| № | Аймаг, сумын нэр | Байгууллагын нэр     | Хөрөнгийн нэр            | Ашиглалтанд орсон өдөр | Хэмжээ | Тоо хэмжээ | Балансын үнэ /төг/ | Байгуулсан элэгдэл /төг/ | Үлдэгдэл үнэ /мян.төг/ | Данснаас хасаж шалтгаан                               | Байгууллагын санал /төг/                                 | ОНӨГ-ын үнийн санал /төг/                  | Аймгийн ИТХ-ын шийдвэр /төг/               |
|---|------------------|----------------------|--------------------------|------------------------|--------|------------|--------------------|--------------------------|------------------------|---|--|--|--|
| 1 | Аймаг,           | Хөвсгөл Ус суваг ХХК | 2-р Халуун усны газар    | 2017                   | м2     | 472.7      | 11,817,500         | 623,496                  | 11,194,004.05          | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоол | дуудлагаар худалдах үнэ 11.817.500                       | дуудлагаар худалдах үнэ 11.817.500         | дуудлагаар худалдах үнэ 11.817.501         |
| 2 | Аймаг,           | Хөвсгөл Ус суваг ХХК | 2-р Халуун усны барилга  | 2002                   | ком    | 1          | 18,685,695.6       | 623,496.0                | 18,062,199.64          | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоол | дуудлагаар худалдах үнэ 18100000                         | дуудлагаар худалдах үнэ 18100000           | дуудлагаар худалдах үнэ 18100001           |
| 3 | Аймаг,           | Хөвсгөл Ус суваг ХХК | LSG-0065 халаалтын тогоо | 2013                   | ш      | 1.00       | 5,300,000          | 3,263,973                | 2036027                | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоол | үлдэх өртөгөөр дуудлага худалдаанд оруулах               | үлдэх өртөгөөр дуудлага худалдаанд оруулах | үлдэх өртөгөөр дуудлага худалдаанд оруулах |
| 4 | Аймаг,           | Хөвсгөл Ус суваг ХХК | Вентилятор               | 2019                   | ш      | 1          | 36,180             | 36,180                   | -                      | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоол | дуудлага худалдаанд оруулах                              | дуудлага худалдаанд оруулах                | дуудлага худалдаанд оруулах                |
|   |                  |                      |                          |                        |        |            | 35,839,376         | 4,547,145                | 31,292,231             |   | багцаар 32,000,000 төгрөгөөр дуудлага худалдаанд оруулах |  |  |